



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/41

Шивээговь сум

Засаг даргын дэргэдэх орон тооны бус
 байнгын зөвлөлийг шинэчлэн
 байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журам”-ын 3.3, 3.4, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/77 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Малчнаар ажиллаж байсан А” дансны лавлагаа, малчин даатгуулагч ажилд томилогдсон, чөлөөлөгдсөн тухай тушаал, хөлсөөр ажиллах /ажил гүйцэтгэх гэрээ, тэдгээртэй адилтгах/ гэрээ байхгүй тохиолдолд түүний малчнаар ажиллаж байсан хугацааг тодорхойлох Засаг даргын дэргэдэх орон тооны бус байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Ц.Цэрэндорж

(Засаг даргын Тамгын газрын даргын
 үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Д.Сувд-Эрдэнэ

(1 дүгээр багийн Засаг дарга)

С.Отгонбаатар

(2 дугаар багийн Засаг дарга)

Л.Алдар

(Улсын бүртгэгч)

Ш.Буяннэмэх

(Соёлын төвийн Номын санч)

Нарийн бичгийн дарга:

Г.Адъяасүрэн

(2 дугаар багийн иргэн)


Б.Мөнхцэцэг

(Нийгмийн даатгалын хэлтсийн
сумын байцаагч)

2. Малчин, даатгуулагчийн материалыг үндэслэн малчнаар ажилласан хугацааг үнэн зөв, бодитойгоор тодорхойлохыг /Зөвлөл/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/39 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ